3

САНХҮҮГИЙН ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТЫН АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Ц.Аюурзана, Н.Баяртсайхан

Санхүүгийн арга, хөшүүрэг, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, санхүүгийн ажлын арга барилыг бодитой шинэчлэх замаар санхүүгийн бодит харилцааг тодорхой зорилгод нийцүүлэн оновчтой удирдаж, алсын хараатай, үе шаталсан үр дүнд туйлбартай хүрэхийг санхүүгийн өөрчлөн байгуулалт гэж үзнэ.

Санхүүгийн бодит харилцаа нь үндэсний болон дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хуваарилагдаж, дахин хуваарилагдаж байгаа тэр орчинд, өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгжийн төвшинд үүсч, тэндээ болон цааш салбарлан хөгждөг. Уг харилцаа нь хөрөнгийн (капиталын) эргэцийг түргэтгэх, үйлдвэрлэл, хэрэглээг идэвхжүүлэх зорилгоор мөнгөн хөрөнгийг оруулах, ашиглахтай холбогдсон харилцаа юм.

Санхүүгийн харилцааны бас нэгэн үндсэн шинж чанар бол нийгмийн (төсвийн), аж ахуйн нэгжийн (өөрийгөө санхүүжүүлэх), хувь хүний эдийн засгийн сонирхлыг оновчтой хослон хэрэгжүүлэх материаллаг (мөнгөн) харилцаа юм.

Санхүүгийн харилцаа нь аж ахуйн нэгжийн дотоодод (анхдагч харилцаа), аж ахуйн нэгжүүдийн хооронд, аж ахуйн нэгж, төв, орон нутгийн хооронд, аж ахуйн нэгж, санхүү, банкны байгууллагын хооронд, аж ахуйн нэгж ба үнэт цаасны зах зээлийн хооронд, аж ахуйн нэгж ба банк бус санхүүгийн байгууллагын хооронд, санхүүгийн байгууллагаар зуучлуулан бүлэг, иргэдийн хооронд гэхчилэнгээр үүсч харилцан шүтэлцээтэйгээр хэрэгждэг бодит харилцаа. Энэ харилцаа нь чухамхүү аж ахуйн нэгжийн өөрийгөө санхүүжүүлэх чадвараас үүдэлтэй бөгөөд дээд шатны ямар нэг байгууллага, албан тушаалтны хүссэн зоргоор болдоггүй, жам ёсны харилцаа юм. Хамгийн гол нь санхүүгийн анхдагч харилцаа бол аж ахуйн нэгжийн зохистой хэмжээ,

түүний төрөлжилт, хоршилтонд суурилсан харилцаа, аж ахуй хоорондын тогтвортой хэлхээ холбоонд үндэслэсэн харилцаа юм. Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгжийн зохистой хэмжээ, үйлдвэрлэл, хөдөлмөрийн дотоод, гадаад төрөлжилт, хоршилт, аж ахуйн хоорондын тогтвортой хэлхээ холбоо бол бүх шатанд санхүүгийн харилцаа бодитой бөгөөд тогтвортой байх, өргөжиж гүнзгийрэх бодит үндэс юм. Иймээс санхүүгийн өөрчлөн байгуулалтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлье гэвэл макро түвшинд авч байгаа арга хэмжээ нь санхүүгийн анхдагч харилцааг хөгжүүлэхэд бодитой түлхэц болдог, түүнчлэн аж ахуйн нэгж байгууллагын түвшинд өөрийгөө санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь макро түвшингийн үзүүлэлтүүдэд шууд эерэгээр нөлөөлдөг тийм орчин, механизмыг бий болгох хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, макро юмуу микро түвшинд тус тусдаа асуудал шийдвэрлэх гэж оролдоод, тэр нь бие биедээ шууд нөлөөлж чадахгүй байх явдал хэвийн үзэгдэл болоод байгааг анхаарч, макро ба микро түвшин дэх санхүүгийн харилцааг холбогч тэр хэсэгт санхүүгийн өөрчлөн байгуулалтыг хандуулах хэрэгтэй байна. Ялангуяа санхүүгийн анхдагч харилцаа (аж ахуйн нэгжийн түвшин дэх), түүнээс үүсмэл хоёрдогч шатны харилцаа (төсвийн, банкны болон банк бус санхүүгийн зах зээлийн, үнэт цаасны зах зээлийн гэх мэт)-ны харилцан хамаарал, шүтэлцээг зөв төлөвшүүлэх явдал нэн чухал болоод байна.

Цаад бодит харилцааны цар хүрээ, агуулгыг үл харгалзан аль нэг субъектын үйл ажиллагааг таамгаар бужигнуулж, өөрчлөн байгуулалт нэрийн дор бодит боломж нь бүрдээгүй зүйлийг шаардах, амлах нь үр дүн муутай байдгийг практик бэлхнээ нотолдог. Ялангуяа зорилго-механизм-зохицуулалт-зохион байгуулалт-тохируулга-хяналт-эргээд харилцаа гэсэн гинжин хэлхээг хатуу барьж өөрчлөн байгуулалтыг хийх учиртай. Тэгэхдээ санхүүгийн харилцаа бол эд юмсаар (мөнгөн хөрөнгийн сангаар) дамжсан хүмүүсийн хоорондын харилцаа гэдгийг байнга анхаарах ёстой.

Санхүүгийн тогтолцооны бүх эд эсүүд, бүх түвшин дэх санхүүгийн субъектүүдийн үйл ажиллагаа нь чухамхүү тэдгээрийн үндсэн суурь бөгөөд цем болсон аж ахуйн нэгжийн өөрийгөө санхүүжүүлэх чадвар дээр суурилан, түүнээс үржил шимээ аван хөгжин тэлэх тийм нөхцлийг бүрдүүлэхэд санхүүгийн өөрчлөн байгуулалтын утга учир оршино. Өөрөөр хэлбэл, засгийн газар, дээд шатны санхүүгийн субъектүүд нийгмийн эрх ашгийг бүхэлд нь төлөөлж, хэрэгжүүлэгчийн хувьд санхүүгийн өөрчлөн байгуулалтыг санаачлагч, эхлүүлэгч, орчин бүрдүүлэгчийн үүрэг гүйцэтгэх боловч өөрчлөн байгуулалтын жинхэнэ бодит үйл явц нь чухамхүү аж ахуйн нэгжийн түвшинд хэрэгжиж, бодит үр дүнгээ өгч байж, тэр нь эргээд макро эдийн засгийн үзүүлэлтээ сайжруулахад жинхэнэ ёсоор нөлөөлж байвал эдийн засгийн харилцаа зөв гольдролоо орж байгаа нь тэр болно. Гэтэл одоо байдал өөр байгаа нь хэн бүхэнд мэдрэгдэж байна.

Сүүлийн үед, ялангуяа 2000 оноос манай эдийн засгийн үзүүлэлтүүд сайжран тогтворжиж, инфляц эрс буурч, ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувийн жин багасах хандлагатай болж байна. Гэлээ ч манай оронд одоогоор санхүүгийн харилцаа бүрэн тогтворжиж өндөр хурдацтай хөгжлийг тэтгэх зөв тэнцвэрт харилцаа бүрэлдэн тогтож чадаагүй байна. Эдийн засаг бол тэнцвэрт харилцаа мөн гэсэн үг байдаг. Гэтэл аж ахуйн нэгжийн түвшинд эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдийн тэнцвэр алдагдах

явдал архагшсан нь эцэстээ макро үзүүлэлтүүдийн тэнцвэрт ч сөргөөр нөлөөлж байна. Мөн түүнчлэн макро түвшинд ч зарим гол тэнцвэрүүд оновчтой бус төлөвлөгдөж байгаа нь эргээд бодит салбарын үзүүлэлтэнд муугаар нөлөөлдөг. Тэр бүгдийг тоочвол асар олон үзүүлэлтүүдийг нэрлэж болно. Наад зах нь мөнгөний нийлүүлэлт, бүтээмжийн, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, төсвийн, капиталын өгөөж, капитал зэвсэглэмжийн, зардлын ба цэвэр бүтээгдэхүүний, өөрийгөө санхүүжүүлэх чадвар, хөрөнгө дайчлах боломжийн гэх мэтчилэн гол чухал үзүүлэлтүүдийн хоорондын харьцаанууд хэвийн болох яагаа ч үгүй байна. Аж ахуйн нэгжүүд тогтвортой хөгжлийнхөө зохистой хэмжээнд хүрч төлөвшөөгүй, аж ахуй хоорондын тогтвортой хэлхээ холбоо бий болж, эдийн засгийн бие биеэ тэтгэх амьд цогцос бүрдэж амилаагүй байна. Аж ахуйн нэгжийн өөрийгөө санхүүжүүлэх чадвар нэн дорой, тэгснээр өр авлагын сүлжээ үүсч, төсвийн орлогын эх үүсвэр тогтворжиж чадаагүй байна. Банкны зээллэг төсөл нэртэй амиа аргацаах арга хэмжээнд урсаж аж ахуй хоорондын болон үйлдвэрлэл хоорондын хоршилтыг хангах, эцсийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдэхгүй байна. Санхүүгийн бодит харилцааны чиг хандлага, түүний менежментийн хооронд ихээхэн том хий орон зай, зөрчил бий боллоо. Санхүүгийн өөрчлөн байгуулалт нь зөвхөн макро буюу эсвэл микро түвшинд тус тусдаа хэрэгждэг бус харин энэ хоёрын уулзвар дээр харилцан шүтэлцээнд нь хэрэгждэг байтал зөвхөн макро түвшинд бүтцийн өөрчлөлт нэрээр зарим субъектийн үйл ажиллагааг өөрчлөх, орон тоо, боловсон хүчнээр оролдох зэргийг өөрчлөн байгуулалт гэж үзэх явдал гарсаар байна. Менежментийн асуудалд иж бүрэн хандахгүй зөвхөн зарим хэсгийг нь бага зэрэг шинэчлэх байдлаар өөрчлөн байгуулалт хийгдэхгүй гэдгийг анхаармаар байна. Бүтцийн өөрчлөлт гэдэг бол үндсэн харилцаагаа зөв гольдролд нь оруулж хөгжүүлэх явдал мөн.

Санхүүгийн анхдагч харилцаа тогтворжиж аж ахуйн нэгж байгууллагууд өөрийгөө санхүүжүүлэх зарчимд бүрэн шилжиж, зохистой хэмжээндээ хүрч төлөвшөөгүй нөхцөлд тэдний зүгээс төв, орон нутгийн төсөв, банк, санхүүгийн байгууллагуудтай хэвийн зөв харьцаанд орж, улс орны санхүүг бүхэлд нь эрүүлжүүлнэ гэж байхгүй. Суурь харилцааг зөв гольдролд нь оруулаагүй нөхцөлд хэвийн бус өр авлага үүсэх, татвараас зайлсхийх, үнэт цаасны зах зээл, даатгалын тогтолцоо нурах, хэт жижиг, сульдаатай, амиа аргацаасан аж ахуйнууд олшрох, аж ахуй хоорондын харилцаа тогтвортой биш, тохиолдлын шинж чанартай болох, тэгснээр авч хэрэгжүүлж байгаа зарим зөв арга хэмжээнүүд нөхцөл нь бүрдэж дараалаа олоогүйгээс бүтэлгүйтэх хөрс суурь байсаар байх болно. Иймээс санхүүгийнхээ суурь харилцааг туйлбартай шинэчлэх шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд төв, орон нутгийн татварын албатай харилцагч аж ахуйн нэгжийн тоо өсөхийн оронд харин харьцангуй цөөрөх хандлагатай байгаа нь аж ахуйн нэгжүүд зохистой хэмжээндээ хүрч өөрийгөө санхүүжүүлэх чадвар нь сайжирч байна гэсэн үг биш юм. Тэр ч байтугай нэгэнт байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байсан хувьцаат компаниуд хязгаарлагдмал хариуцлагатай юм уу, эсвэл бүрэн бус хариуцлагатай компани болон хувирч байгаа нь зах зээлийн харилцааны хөгжлийн чиг хандлагатай зөрчилдөхөд хүрч байна. Энэ байдал хүснэгт 1-ийн материалаас тод харагдаж байна.

Аж ахуйн нэгжүүдийн бүтэц (тоогоор)

Хүснэгт 1

	1995	1996	1997	1998	1999	2000	2001
ХЭАА	27816	22375	19087	8843	4931	4395	4148
Хоршоо	3599	2111	2711	2626	2033	1872	2022
Нөхөрлөл	133	1339	2069	2741	3449	3692	3819
Хувьцаат компани	498	423	447	443	398	396	398
ХХк (ББХк)	5598	5955	7516	8652	9935	12047	13643
ТӨҮГ (УҮГ)	1136	1153	1006	904	617	474	473
Нийт	38880	33356	32836	24209	21363	22876	24503

Эх сурвалж: ҮТЕГ-ын материалд тулгуурлав.

Ийнхүү төсөвтэй харилцагч аж ахуйн нэгжийн тоо бүхэлдээ цөөрч 2001 оны байдлаар төсөвтэй харилцаж байгаа нийт 24503 аж ахуйн нэгжийн дотор ХХК (ББХК) 55.7 хувь, ХК дөнгөж 1.6 хувь, ТӨҮГ (УҮГ) 1.9 хувь тус тус эзэлж бусад нь ХЭАА, хоршоо, нөхөрлөлийн хэлбэртэй байна. Гэтэл зах зээл хөгжсөн орнуудад аж ахуйн нэгжийн үндсэн хэлбэр нь хувьцаат компани байдаг бөгөөд тийм ч байхаас аргагүй гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой.

Дээр дурьдсанаас гадна манай аж ахуйн нэгжүүд хэтэрхий жижгэрсэн, төлбөрийн чадвар муутай нь судалгаанаас тодийгүй хэний ч нүдэнд ил байгаа юм. 2000 оны байдлаар бидний том татвар төлөгч гэж нэрлэгдэж байгаа тэр татвар төлөгчид цөөрч 76 болж өмнөх жилүүдээсээ тоо нь цөөрч ирсэний дээр энэ нь нийт татвар төлөгчдийн тоонд зөвхөн 0.36 хувийг эзэлж байгаа мөртлөө нийт цуглуулсан татварын 60.8 хувийг бүрдүүлж байв. Гэтэл эдгээр компаниуд нь бусад өндөр хөгжилтэй орнуудынхтай харьцуулбал тийм ч том биш, бүтэц менежментийнхээ хувьд ч анхаарвал зохих зүйл маш их байгаа нь нууц биш билээ. Эдийн засгийн төв, орон нутгийн байгууллагууд эдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ захиалга, эдийн засгийн төрөл бүрийн урамшуулал, хөшүүргийг хэрэглэж идэвхтэй аргаар хамтран ажиллахын оронд харин ч ил далд байдлаар дарамтлах, захиргаадах байдлаар ажилладаг тухай бизнесийнхэн гомдоллодог нь оргүй зүйл биш. Үүний дээр татварын жигд, тогтвортой орчин бүрдээгүй байгаа нь ч аж ахуйн нэгжийн жижгэрэх үйл явцад нөлөөлж байгааг үгүйсгэхгүй.

Татварын албаны тоо баримтанд тулгуурлан дундажлан авч үзсэн зарим үзүүлэлтээс үзвэл манай орны аж ахуйн нэгжид ногдож байгаа дүрмийн сан ихээхэн бага, ажиллагсдын тоо бүтээмжийн харьцаа алдагдсан, өөрийгөө санхүүжүүлэх чадвар нь сонгомол утгаараа маш доогуур, төлбөрийн чадвар ба ашигт ажиллагааны үзүүлэлтийн (энэ хоёр үзүүлэлт нь хоорондоо зөрчилтэй байдаг) оновчтой харьцааг барьж чадахгүй байгаа зэргээс татвар төлөх чадвар нь олигтой дээшилж чадахгүй байна. Байгалийн баялаг олзворлох салбарт нэг ХХК-д ногдох дүрмийн сан дунджаар 94.7 сая төгрөг байхад ойролцоогоор 3.0 сая төгрөгийн орлогын албан татвар төлж байна. Харин энэ салбар дахь нэг хувьцаат компанид дунджаар 283.9 сая төгрөгийн дүрмийн сан ногдож байхад 113.4 сая орчим төгрөгийн татвар төлж байна.

Хөдөө аж ахуй, ан агнуурын салбар гэхэд нэг ХХК-д дунджаар 26.7 сая төгрөгийн дүрмийн сан ногдож байхад ердөө 0.22 сая төгрөгийн татвар төлж байна. Харин энэ салбар дахь нэг хувьцаат компанид дунджаар 102.4 сая төгрөгийн дүрмийн сан ногдож байхад нэг сая төгрөгийн татвар төлж байх жишээтэй. Гэтэл нэхмэлийн салбар дахь нэг хувьцаат компани дунджаар 139.0 сая төгрөгийн дүрмийн сантай байхад 147.4 сая, хэвлэн нийтлэх салбар дунджаар 14.6 сая төгрөгийн дүрмийн сантай байхад 4.3 сая төгрөгийн татвар төлөх жишээтэй. Өнөөгийн нөхцөлд нөхөрлөл, хоршоо, хувиараа эрхлэх аж ахуй нь санхүүгийн хувьд сул дорой, дөнгөж амиа аргацаасан аж ахуйнууд болжээ. Ер нь манай аж ахуйн нэгжүүдийг зохистой хэмжээнд хүргэн төрөлжүүлэх, олзворлох, боловсруулах, борлуулах салбаруудын төрөлжилт, хоршилтыг хангахгүйгээр өөрсдийгөө санхүүжүүлэх чадварыг нь бодитой дээшлүүлэх, татварын орлогыг тууштай нэмэгдүүлэх боломжгүй болох нь судалгаанаас харагдаж байна. Тооцооноос үзэхэд, нэг хувьцаат компанид дунджаар ногдох дүрмийн сан, төсөвт төлсөн төлбөр нь бусад төрлийн аж ахуйн нэгжийнхээс их байгаа нь өмч хувьчлалыг зөв бөгөөд үр ашигтай явуулж чадвал аж ахуйн нэгжийн өөрийн нь санхүүгийн чадвар сайжраад зогсохгүй төсвийн харилцаанд зарчмын өөрчлөлт гарах үндэс болохоор байна.

Аж ахуйн нэгжүүд зохистой хэмжээнд хүрч төрөлжиж чадаагүй нөхцөлд аж ахуй хоорондын тогтвортой харилцаа үүсэх боломж муутай. Гэтэл зах зээлийн нөхцөл дэх санхүүгийн харилцааны эцсийн үр дүн нь чухамхүү аж ахуй хоорондын харилцаан дээр суурилсан байдаг. Энэ харилцаа нь чөлөөт өрсөлдөөний явцад төлөвшин хөгждөг учиртай. Ялангуяа банкны болон банк бус санхүүгийн байгууллагын зээлийн харилцааг үүнд чиглүүлэх нь аж ахуй тус бүрийн дотоод асуудлыг шийдвэрлэхэд олгосноос хавьгүй илүү үр ашигтай болно.

ДНБ-ий салбарын бүтэц (хувиар)

Хүснэгт 2

Салбар	1995	1999	2000	2002
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	38.0	37.0	30.9	26.0
Уул уурхай, олзворлох үйлдвэр	12.0	8.6	11.2	11.7
Боловсруулах үйлдвэр	12.1	5.9	6.0	7.2
Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж	1.8	3.6	2.4	2.4
Барилга	1.7	2.5	1.8	2.0
Бөөний жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ	17.0	2.5	1.8	2.0
Зочид буудал, зоогийн газар	0.7	1.3	1.3	1.4
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	6.4	9.2	10.7	11.7
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	1.2	2.2	2.4	3.5
Бусад үйл ажиллагаа (төрийн ба нийгмийн үйлчилгээ)	9.1	8.9	9.8	9.5
Бүгд	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**

Эх сурвалж: ҮСГ, Статистикийн эхмтгэл. УБ 2002. Урьдчилсан дүн 2003.

Цаашлаад гадаадын зээл тусламжийн хөрөнгийг ч гэсэн бизнесийн тааламжтай орчинг бүрдүүлэх арга хэмжээний зэрэгцээ аж ахуйн нэгжүүдийн зохистой хэмжээг хангаж, төрөлжилт, хоршилтыг гүнзгийрүүлэх, үүний үндсэн дээр эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээнд түлхүү хандуулмаар байна. Дээр дурьдсан бодит баримтуудын дээр дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын одоогийн бүтэц нь дээрх дүгнэлтэнд зайлшгүй хүргэж байна.

Ийнхүү дотоодын нийт бүтээгдэхүүний 47.3 хувь нь бодит салбарт бий болж, бусад 50.7 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт бий болж байна. ДНБ-д боловсруулах салбарын эзлэх хувийн жин дөнгөж 7.2 хувийг эзэлж байна. Харин 2002 оноос зарчмын өөрчлөлт гарч байгааг хэлэх хэрэгтэй. Гэхдээ л онолын үүднээс авч үзвэл энэхүү бүтэц нь түүхий эдийн хавсарга байдалтай, хэрэглээний шинжтэй, үр ашиг багатай, мөнгө хүүлэх төрхийг агуулсан эдийн засгийн дүр төрхийг илтгэж байна. Энэ нь салбар хоорондын болон салбарын дотоод дахь үйлдвэрлэлийн төрөлжилт, хоршилт нэн сул байгааг илтгэхийн зэрэгцээ санхүүгийн суурь харилцаа хөгжөөгүй, ДНБ-ий дахин хуваарилалт зонхилж байгааг харуулж байна. Цаашлаад ДНБ-ий жилийн дундаж өсөлтийн тоо баримтыг авч үзвэл санхүүгийн харилцаа тогтворгүй байгаа нь бүр ч илт харагдаж байна.

ДНБ-ий жилийн дундаж өсөлт (хувиар)

Хүснэгт 3

Салбар	1995	1999	2000	2002
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	4.4	4.2	-14.4	-16.0
Уул уурхай, олзворлох үйлдвэр	6.1	3.2	6.1	10.5
Боловсруулах үйлдвэр	-13.8	-2.8	-3.3	20.0
Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж	0.7	4.6	0.4	2.4
Барилга	2.6	1.6	-14.6	12.4
Бөөний жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ	0.3	1.3	25.7	8.0
Зочид буудал, зоогийн газар	6.8	8.7	13.2	10.5
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	11.2	6.1	25.2	11.8
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	42.2	39.9	7.0	47.0

Эх сурвалж: ҮСГ, Статистикийн эмхтгэл 2001 УБ, 2002. 2002 оны урьдчилсан гүйцэтгэл 2003

Эндээс салбаруудын үйлдвэрлэл тогтворгүй, ДНБ-ий өсөлт нь олзворлох болон худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтөөр голлон тодорхойлогдож байгаа нь харагдаж байна. Боловсруулах салбарт өсөлт харагдаж байгаа боловч суурь нь их уналттай байсан учраас бодит үр дүнд хүрэх болоогүй байна. ХАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл дорвитой хөгжихгүй байгаа мөртлөө архи, тамхи, мод модон эдлэлийн үйлдвэрлэл эрчимтэй өсөөд байгаа нь сонирхол татж байна. ХАА-н салбарт огцом уналт гарсан нь байгаль, цаг уурын тааламжгүй нөхцөлтэй холбоотой боловч бусад салбарууд дахь огцом өөрчлөлт нь бие биеэ тогтвортой дэмжих аж ахуйн тогтвортой хэлхээ холбоо үүсээгүй, үйлдвэрлэлийг дэмжих санхүүгийн нөөц дутагдалтай, санхүүгийн урамшуулагч механизм бүрэлдэн тогтож чадаагүй, аж ахуйн

нэгжүүд хувь хувьдаа амиа аргацаасан байдалтай үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа эрхэлж байгаатай холбоотой.

Манай орны эдийн засгийн өсөлт, салбарын бүтэц нь хэрэв энэ чигээрээ явбал дэлхийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагаас хоцрох төлөвтэй байна. Дэлхийн улс орнууд зөвхөн эдийн засгийн өсөлтийг төдийгүй хүн төвтэй эдийн засгийн хөгжлийг чиг баримжаагаа болгон эрчимтэй замаар хөгжиж байна. Улс орнуудын хоорондын худалдааны эргэлтэнд бэлэн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин эрс өсөж, түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүний хувийн жин буурч байгааг хүснэгт 4 дэх тоо баримтаас тодорхой харж болохоор байна.

Дэлхийн экспортын таваарын бүтцийн хандлага
(дүнд харьцуулсан хувь)

Хүснэгт 4

Таваарын бүлгүүд	Өнөөгийн байдал		Прогноз		
Бэлэн бүтээгдэхүүн	70.4	77.5	80.8	83.2	85.3
Үүнээс:					
- Машин, тоног төхөөрөмж	35.8	41.9	44.8	47.4	49.5
- Химийн бүтээгдэхүүн	8.5	9.6	9.9	10.2	10.3
- Завсрын хөрөнгө оруулалтын таваар	7.8	7.6	7.3	6.5	6.5
- Нэхмэл ба хувцас	6.3	6.1	5.9	5.9	5.4
- Хэрэглээний бусад таваар	11.9	12.3	12.9	13.4	13.6
Түүхий эд хагас боловсруулсан бүтээгдэхүүн	17.4	12.5	10.4	8.9	7.6
Үүнээс:					
- Түлш	10.5	7.3	6.1	5.3	4.4
- Хар металл...	3.1	2.3	1.9	1.6	1.4
- Өнгөт металл...	2.1	1.8	1.6	1.5	1.3
- Хүдэр болон бусад эрдэс түүхий эд	1.7	1.1	0.8	0.6	0.5
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн	12.2	10.0	8.0	7.9	7.1
Үүнээс:					
- Хүнсний бараа	9.3	8.0	7.2	6.6	6.0
- ХАА-н түүхий эд	2.9	2.0	1.6	1.3	1.1.

Эх сурвалж: Мир на рубеже тысячилетий. Прогноз развития мировой экономики до 2015 г. М:имэмо РАН, 2001, с-169.

Дэлхийн энэхүү чиг хандлагатай уялдуулан эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх явдал цаг үеийн хатуу шаардлага болон тулгарч байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн шинэтгэлийг хийхдээ цогцолбор, зорилтот программын үүднээс хандаж, дор дурьдсан асуудлуудад гол анхаарлаа төвлөрүүлмээр байна. Тухайлбал:

- XXI зуунд Монголын эдийн засгийн бүтэц ямар байх вэ? гэдгийг хот, хөдөөгөөр, хүний хөгжлийн асуудалтай нь холбож иж бүрэн харуулсан хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулж иргэд, олон нийтийн үйл ажиллагааны хөтөлбөр болгох нь чухал. Энд манай бүх аж ахуйн нэгжүүд хэлбэрийн төдийд бус, жинхэнэ агуулгаараа зах зээлийн харилцаанд бүрэн шилжих, ашиглалтанд байгаа машин, тоног төхөөрөмжийг тууштай шинэчлэх, техник, технологийн хөгжлийг угтсан

үйлдвэрлэл, технологийн бодлого явуулах, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг эрс дээшлүүлэх явдал гол зорилт болно. Үүнийг хүн хийх учраас хүнээ боловсролжуулахаас гадна илүү чадваржуулах, үйл ажиллагаагаараа эх орноо гэсэн сэтгэлтэй болгох хэрэгтэй. Энэ бүхнийг эс хэрэгжүүлбэл улам хоцрогдох нь гарцаагүй болохыг дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн чиг хандлага харуулж байна.

- Монгол оронд XXI зуунд эдийн засгийн түүхий эдийн үйлдвэрлэл, байгалийн баялагаа олзворлох хандлага хэвээр хадгалагдах уу, эсвэл өндөр технологид суурилан боловсруулах үйлдвэрлэлийн чигийг барих уу, хэрэв боловсруулах үйлдвэрлэлээ хөгжүүлбэл чухам ямар салбарыг голлох вэ? гэдэг асуудлыг нэг мөр болгон дэвшүүлж тавихгүй бол "Дээд хүн суудлаа олохгүй бол доод хүн гүйдлээ олохгүй" гэсэн Монгол ардын цэцэн үг байдагчлан аж ахуйн нэгжийн хувьд ч, ард иргэдийн хувьд ч ирээдүйгээ харж хөрөнгө оруулалт хийх, мэргэшил чадвараа алсын хараатай сайжруулах нөхцөл баримжаа хомс байх болно.

- Дараагийн чухал асуудал бол Монголд цаашдаа үйлдвэр-санхүүгийн том бүлэглэлүүд зонхилох уу, эсвэл жижиг, дунд үйлдвэрлэл голлох уу, ер нь хот, хөдөөд өрсөлдөөний нөхцлийг яаж бий болгох вэ? гэдэгт тодорхой хариулт шаардагдаж байна. Манай орны эрх ашиг нь хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн хосолмол томоохон аж ахуйн нэгжүүд, хөдөөгийн гүнд бол жижиг, дунд үйлдвэрүүд, эцсийн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнгаргах, олзворлох ба боловсруулах үйлдвэрийн нэгдлүүд илүү үр дүн өгнө гэж үзэхээр байна.

- Эдийн засгийн шинэтгэлийг хэрэгжүүлэх, ялангуяа хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд хувийн секторын идэвх, санаачилга, олон нийтийн хөдөлгөөн асар их ач холбогдолтой бөгөөд төр засаг асар их зардал, хүнд суртал хоёроороо үүнийг өөрөө хийх гээд байх биш, харин дээрх санаачилга, хөдөлгөөнүүдийн очийг бадрааж, тууштай дэмждэг байх нь чухал байна.

Чухамхүү гарцаагүй шийдэхээс аргагүй дээрх асуудлуудаар оновчтой бодлого, үйл ажиллагаа өрнөсөн нөхцөлд хот, хөдөөгийн эдийн засгийн чадавхи ойрын ирээдүйд болон алсдаа ямар болох, тэгснээр хүний хөгжлийн боломжийг яаж бүрдүүлэх асуудал цэгцэрч ирэх нь тодорхой юм. Энэ бүхэн бол хүнээс гадуур асуудал биш, харин дээрээ чухамхүү хүний бодит хөгжлийн тухай хамгийн тодорхой хариулт нэхсэн асуудлууд мөн.

Иймхүү санхүүгийн өөрчлөн байгуулалтыг эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөнд хандуулах шаардлагатай байгаа нь илт байна. Харин үүнийг хийхдээ дотоод хуримтлал хүрэлцээгүй гэх мэтчилэн шалтгаан тавих биш, бүх нөөц боломжоо бүрэн гүйцэд дайчилж, зорилт программаа тодорхой болгож, ажлын байр, аж ахуйн нэгж, байгууллага бүрээс эхлэн бодитой хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Аж ахуйн нэгжүүдийг ард иргэддээ нээлттэй болгох хэрэгтэй байна. Хэрэв аж ахуйнууд маань одоогийнх шигээ өөрийн ард иргэддээ хаалттай байх юм бол бид яаж дэлхийд нээлттэй эдийн засаг бий болгох юм бэ? Тухайн аж ахуйн нэгж ямар техник, технологи нэвтрүүлж өрсөлдөөнд оролцох гэж байгаагаа л нуудгаас биш, бусад үзүүлэлтүүд ялангуяа

өмчийн эздэд, ажиллагсад, харилцагсаддаа ойлгомжтой, нээлттэй хүрч баймааж, тэр ч байтугай төлөвлөгөөт үзүүлэлтүүд, түүнийг дагасан урамшууллын механизм нь хүн бүрийн сонирхлыг татаж байж бизнес урагшаа хөгждөг нь тодорхой юм. Энэ чиглэлээр манайд ихээхэн зүйлийг цаг алдалгүй хиймээр байна. Ялангуяа тайлан тэнцэлд суурилсан хойшоо харсан менежментээс санхүүгийн төлөвлөгөөг гол хэрэгслээ болгосон урагшаа харсан менежмент рүү тууштай шилжмээр байна. Манай санхүүгийн байгууллагууд энэ талаар хөшүүн хойрго ажиллаж байгааг зөвтгөх аргагүй байна.

Сүүлийн жилүүдэд санхүү, банкны секторт тодорхой хэмжээний шинэчлэл хийгдсэн нь үр дүнгээ өгч байна. Гэхдээ энэ нь бодит секторт хийгдсэн шинэтгэлийн үр дүн биш, харин түүнээс салангид явж ирсэн нь бидний дутагдал юм. Цаашдаа санхүүгийн шинэтгэлийг аж ахуйн нэгжийн санхүүгээс иш үндэстэй болгож, (уг харилцаа нь тийм болохыг дээр авч үзсэн), нэгдмэл, чиглэсэн зорилготой, тодорхой дэс дараалалтай болгож, үр дүнг нь тодорхой үзүүлэлтээр дүгнэх бололцоотой тийм эмх журамд оруулмаар байна. Эцэс төгсгөлгүй шинэчлэл хийж, өөрчлөн байгуулаад байж болохгүй.

2001 онд арилжааны банкуудаас аж ахуйн нэгжид олгосон зээлийн хэмжээ ихээхэн нэмэгдэж, зээлийн өрийн үлдэгдэл 2.0 дахин өссөн байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл эрс буурч 13.2 тэрбум төгрөг болсон нь нааштай хандлага боловч олгож байгаа зээл нь аж ахуйн нэгжүүдийн төрөлжилт, хоршилтыг гүнзгийрүүлж, аж ахуй хоорондын тогтвортой харилцааг хөгжүүлэхэд чиглэгдээгүй явж ирсэн нь бүхэлдээ санхүүгийн харилцааг тогтворжуулах үндэс болж чадсангүй.

Монголын үнэт цаасны зах зээлийн уналт нь аж ахуйн нэгжийн түвшинд санхүүгийн өөрчлөн байгуулалт явагдаагүй, тэдний зохистой хэмжээ бүрдэж, санхүүгийн зохих чадвар суугаагүйтэй холбоотой.

Сүүлийн жилүүдэд төрөөс мөнгө-зээлийн болон төсвийн зохицуулалтын шинэчлэлтэй холбогдсон олон чухал хууль гаргаж, практик алхмуудыг хийж байна. Банкны тухай хуульд өөрчлөлт оруулж, нягтлан бодох бүртгэлийн хуулийг шинэчлэн баталж, төсвийн байгууллагын төлөвлөлт санхүүжилтийн хуулийг гаргаж, төсөв хоорондын харилцааг хөгжүүлэх шинэ программыг хэрэгжүүлж байна. Засгийн газар санхүүгийн өөрчлөн байгуулалтыг санаачлан зарим өөрчлөлтүүдийг хийж байгаа боловч түүнийг микро түвшинд зэрэгцүүлэн хийхгүй бол дорвитой амжилтанд хүрдэггүйг практик нотолж байна. Өөрчлөгдөж байгаа шинэ орчин, тавигдаж буй шинэ шаардлагыг харгалзан компанийн тухай хуулийг даруй шинэчилж, аж ахуйн нэгжийн төвшинд санхүүгийн өөрчлөн байгуулалтыг бодитой, цаг алдалгүй хийх нь чухал байна.

Монголын эдийн засагт шинэ хөрөнгө оруулалт тэргүүлэх ач холбогдолтойг иш үндэс болгон, түүнчлэн 2001 онд хөрөнгө оруулалт 1995 оныхоос 3.3 дахин өсөж 307.1 тэрбум төгрөгт хүрсний дотор барилга угсралтын ажил 1.5, машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эд хогшил 4.8 дахин өссөн үр дүндээ тулгуурлан засгийн газраас 2002 оныг хөрөнгө оруулалтын жил гэж зарласан нь санхүүгийн харилцааг өргөжүүлэн бэхжүүлэхэд бодит үр дүнгээ өгөх учиртай. Нийт хөрөнгө оруулалтын эх үүсвэрт /

2001 оны байдлаар/ төсвийн хөрөнгө 13.3%, банкны зээл дөнгөж 8.0%, компаний өөрийн хөрөнгө 19.5%-ийг, үлдсэн 58.6 хувийг гадаадын зээл тусламж эзэлж байгаагаас үзэхэд хөрөнгө оруулалтын дотоод үүсвэр хангалтгүй, түүнийг мөнгө зээлийн бодлогоор дэмжих дэмжлэг сул, гадаад эх үүсвэр, гадны хөрөнгө оруулалтанд найдсан байдалтай байна. Нэгэнт хөрөнгө оруулалтын жил гэж зарлаж байгаа бол зөвхөн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхааралд зогсохгүй гол нь хөрөнгө оруулалтын менежментийг сайжруулах, ялангуяа түүний төлөвлөлтийг шинэ шатанд гаргах, үр ашгийг дээшлүүлэх талаар өөрчлөн байгуулалтыг эхлүүлэх шаардлагатай байгаа боловч энэ тал дээр мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт ажиглагдсангүй нь харамсалтай байна. Хөрөнгө оруулалтын бодлого нь аж ахуйн нэгжийг өөд татаж, зохистой хэмжээнд хүргэх, аж ахуй хоорондын хоршилтыг гүнзгийрүүлэх, санхүүгийн тогтвортой харилцааны үндэс суурийг тавихад голлон чиглэгдмээр байна. Зүйрлэн хэлбэл, манай аж ахуйн нэгжүүд үүлдэр угсаа, ашиг шим, бүтэц тааруухантай мал сүргийг, харин банк, санхүүгийн /төсвийн/ байгууллагууд нь үүнийг алсын хараатай, үе шаттай, тууштай шинэчлэх талаар дорвитой амжилт олоогүй мөртлөө ахиухан ашиг шим авахын төлөө улайран зүтгэдэг бүтэл муутай малчны дүр төрхийг санагдуулам байгаа одоогийн харилцааг эрс өөрчлөхөд хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүлж, санхүүгийн өөрчлөн байгуулалтыг энэ зүгт хандуулах шаардлагатай байна.

Одоогийн байдлаар санхүүгийн харилцаа үүсч, хэрэгждэг үндсэн нэгжид уг харилцааг зохион байгуулах үүрэг бүхий нарийн мэргэшсэн алба байхгүй, түүнийг нягтлан бодох бүртгэлийн албаар оруулсан байдалтай байгаагаас санхүүгийн урт, дунд, богино хугацааны төлөвлөлт, санхүүгийн шинжилгээ оношлогоо, хөрөнгө оруулалтын бодлого, менежмент, үнэт цаасны удирдлага, санхүүгийн арга хөшүүргүүдийн харилцан шүтэлцээг хангажүйлдвэрлэлийг урамшуулахад чиглүүлэх, санхүүжилтийн орчин үеийн үр ашигтай арга хэлбэрүүдийг цаг алдалгүй нэвтрүүлэх, төсөв, санхүү, банкны байгууллагуудтай мэргэжлийн үүднээс харилцах, аж ахуй санхүүгийн үйл ажиллагаанд гэрээ хэлцлийн болон итгэлцлийн харилцааны үүрэг байр суурийг өндөржүүлэх зэрэг цэвэр санхүүгийн үйл ажиллагаа эзэнгүйдсэн байдалтай байна. Энэ нь санхүүгийн өөрчлөн байгуулалтын талаар төр, засгаас макро түвшинд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нь аж ахуйн нэгжийн түвшинд зөв ойлгогдож цаг хугацаандаа ажил хэрэг болгохын оронд харин ч цаг алдах, тооцоолсон үр дүнд хүрэхэд сөргөөр нөлөөлөх байдлыг бий болгож байна.

Бид энэ дүгнэлтийг хийхдээ санхүүгийн албаны нэн чухал бүрэлдэхүүн хэсэг болох нягтлан бодох бүртгэлийн албаны үүрэг ач холбогдлыг огтхон ч үгүйсгээгүй бөгөөд харин ч түүнийг улам өндөржүүлэх шаардлагатайг иш үндэс болгож байна. Санхүүгийн болон зардал удирдлагын бүртгэл, мэдээ, тайланг улам чанаржуулах, аудитын тогтолцоог хөгжүүлэх, бүртгэлд цаг хугацааны болон хүчин зүйлсийн харилцан шүтэлцээг бүрэн гүйцэд, зөв тусгах, тухайн аж ахуйн өөрмөц нөхцөлд тохирсон норм, нормативын баазыг бүрдүүлэх талаар бүртгэлийн албаны үүрэг ач холбогдол улам дээшилснээр тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаа сайжраад зогсохгүй макро түвшний үзүүлэлтүүдэд ч эерэгээр нөлөөлөх нь тодорхой. Энэ бүхнээс аж ахуйн нэгжийн төвшинд санхүүгийн албыг жинхэнэ утгаар нь санхүүгийн алба, бүртгэлийн албаны нэгдсэн үйл ажиллагааг мэргэшлийн өндөр

түвшинд явуулах хэмжээнд байгуулах нь зүйтэй. Зах зээлийн орнуудад сайн санхүүчийг найдвартай зам заагч, хөтөч гэж үздэг нь оргүй зүйл биш билээ. Ингэснээр аж ахуйн нэгжийн зүгээс төсөв, санхүүгийн байгууллага, банктай харилцах харилцаа мэргэшлийн түвшинд зохицуулагдаж, төр засгаас авч байгаа арга хэмжээнүүд анхан шатандаа бодитой хэрэгжих нэг чухал нөхцөл бүрдэх юм. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулах явцад энэхүү зорилтыг хэрэгжүүлэх нөхцөл бололцоо ч сайжрах учиртай. Санхүүгийн өөрчлөн байгуулалтын хүрээнд зайлшгүй хийх шаардлагатай ажил асар их байгаа бөгөөд бид энэ ажлын дөнгөж эхлэл дээр нь яваа гэдгийг хаана хаанаа анхаармаар байна.